



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Б.ЭНХБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.16 № ХХТ/851
танай _____-ны № _____-т

Санал, дүгнэлтийн төсөл
бэлтгэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяраас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачлан боловсруулж, Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад заасны дагуу санал, дүгнэлтийн төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг хүсье.

Хавсралт ³⁵... хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

990265003734

Хянасан:

Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Эрдэнэчимэг

Боловсруулсан: Ахлах шинжээч Г.Дөлгөөн /.....

Хувь: 2%



「МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД」
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Эрдэнэбилэгийн ОДБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-46, Факс: 32-70-16
E-mail: odbayar@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.03.10 № УИХ-03/2338
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу санал, дүгнэлт авахаар хүргүүлж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл, холбогдох судалгаануудыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Э.ОДБАЯР

2026000018

БАТЛАВ:

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Э.ОДБАЯР

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн шаардлага

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "авлига" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно гэж тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батласан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийн зорилго 6-д "авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэх заалтын 6.1.11 дэх хэсэгт "хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэж заасан.

Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлд анхаарал хандуулж "Авилгатай тэмцэх жил", "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-үүдийг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч тухайн хөтөлбөрт тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх талаар үр дүн бүхий бодит үйлдэл хийгдэхгүй байна. Авлигын талаарх ойлголт, түүнийг үл тэвчих байдал нийгэмд, олон нийтийн дунд нэмэгдэж байгаа хэдий ч итгэлцлийг нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх шинэчлэлийн үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулахын тулд Засгийн газрын зүгээс авлигатай тэмцэх талаар шийдвэртэй алхам хийж, авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажлын арга замаа сайжруулах шаардлага үүсэж байна. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батласан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийн зорилгод хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор тодорхой заасан байна.

Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалт "Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө. -Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх

бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд хүлээлгэх ялыг хөнгөрүүлэх үндэслэл болно.” гэж хуульчилсан.

Хуульд заасан “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгсөн” гэж заасан нь гэмт хэргээ сайн дураараа илчлэхэд хязгаарлалт үүсгэж байна. Авлига өгсөн этгээд гэмт үйлдэлдээ гэмших, хэргээ сайн дураар илчлэх нөхцөлд хясан боогдуулсан гэх нөхцөл тогтоогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхээр байгаа нь Авлигатай тэмцэх хөтөлбөрт заагдсан эрх зүйн орчинг бий болгох зайлшгүй шаардлагыг илэрхийлж байна.

1.2.Практик шаардлага

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад 12 зүйл бүхий “Авлигын гэмт хэрэг” бүлгийг шинээр оруулсан бөгөөд авлигын гэмт хэрэг нь нийтийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэргээр төр, засгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, нийтийн ашиг сонирхолд халдаж хуульд заасан гэм хор учруулсан буюу учруулах байсан Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэл юм.

Хэдийгээр авлигатай тэмцэхэд чухал нөлөө үзүүлэх гол зохицуулалт болох авлига, хээл хахууль өгөх гэмт хэргийн талаар зохицуулалт учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтад байгаа “хясан боогдуулсны улмаас” гэж нөхцлийг тодорхойлсон байгаа нь авлига өгсөн хүн гэмт үйлдэлдээ гэмшсэн байх гол нөхцлийг орхигдуулж зөвхөн хясан боогдуулсан нөхцөл тогтоогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа нь авлига өгөх гэмт хэрэг илрэхгүй байх шалтгаан болж байна.

Авлига өгсөн этгээдийн тухайд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө” гэсэн нь авлига илрэх ганц шалтгаан бүхий заалт юм. Харамсалтай нь, иргэн өөрөө хүсээд, санаачлаад, зохион байгуулаад төрийн албан хаагчид хахууль өгч ажил хэргээ бүтээсэн байлаа ч энэ үйлдэлдээ гэмшээд хуулийн байгууллагад хандахын тулд хясан боогдуулсан гэдгээ батлах шаардлагатай буюу хязгаарлагдмал нөхцөл үүсээд байна. Учир нь хясан боогдуулсан нөхцөлгүйгээр авлига өгсөн хүнд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалт үйлчлэхгүй буюу эрүүгийн хариуцлага хүлээх учир авлигын гэмт хэрэг илрэхгүй байна. Энэ нь авлига цэцэглэх нэг суурь болж байгааг үгүйсгэхгүй.

Дэлхийн олон улс оронд авлига өгсөн этгээд өөрөө хэргээ сайн дураараа илчилж, хуулийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг байна.

Авлигатай үр дүнтэй, бодитоор тэмцэх гол хүчин зүйл болох эрүүгийн хуульд заасан авлига өгөх гэмт хэргийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна.

Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлд 4,5 дахь заалт болох Хахууль өгөх гэмт хэргийг үйлдсэн этгээд хахууль өгснөө нэг сарын дотор эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гол зохицуулалттай, мөн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын "Тайлбар" хэсгийг хасах, хуулийн хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг зааж өгсөн.

Хуулийн төсөл нь дээр дурдсан өөрчлөлтүүдийг тусгасан 3 зүйлээс бүрдэнэ

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс авлигатай тэмцэхэд бодитой хувь нэмэр оруулах гол эрх зүйн үндэс болно. Түүнчлэн Улсын Их Хурлаар баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжих чухал ач холбогдолтой. Авлигатай тэмцэх газарт шалгагдсан гэмт хэргүүдийн 8.4 хувийг авлига өгөх гэмт хэрэг (2024 онд), 2025 онд 7.5 хувийг тус тус эзлэж байсан байна. Хэрэв хахууль өгсөн этгээд гэмт хэргээ сайн дураар илчилсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх нь баталгаатай буюу хуульчлагдсан буюу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно:

- авлигын гэмт хэргийн тоо эрс буурана;
- албан тушаалтан, эрх бүхий этгээд авлига авахаас эмээнэ;
- Монгол Улсын авлигын эсрэг, авлигыг бууруулах үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжинэ;
- иргэд төрийн аливаа үйлчилгээг чирэгдэл багатай, хурдан шуурхай хуулийн дагуу авдаг болно;
- ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ;

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улс авлигатай тэмцэх чиглэлээр олон ажил хийж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг ч төдийлөн үр дүнгүй байгаа нь олон шалтгаантай байна. Авлигатай тэмцэхэд хамгийн чухал арга болох хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг чангатгах, хуулийг хийдэлгүй болгох гэж дүгнэж байна.

Дэлхийн олон улс орнууд авлигатай тэмцэхдээ холбогдох хуульд авлига өгсөн этгээд гэмт хэргээ сайн дураараа илчилж ирвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөдөг байгаа нь авлигын гэмт хэрэг буурахад чухал нөлөө үзүүлдэг болохыг баталж байна.

Гэмт хэргээ сайн дураараа илчлэн ирэх гэдэг нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллага ба шүүхэд сайн дураараа ирж өөрийн үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж байгаа гэмт хэргийн тухай үнэн санаанаас илчлэн ярихыг хэлнэ. Энэ нь гэм буруугаа чин санаанаас гэмшиж, өөрийн үйл ажиллагааны нийгмийн хор аюулыг ухамсарлан жигшиж байгаагийн илрэл учраас ял шийтгэхэд хөнгөрүүлэх шалтгаан болдог. Гэмт хэрэг илрүүлэхэд болон хэрэгтнийг олоход тус дэмжлэг үзүүлэх нь хэрэг үйлдсэн этгээд гэм буруугаа ухамсарлан гэмшиж төрийн байгууллагын ажилд туслан иргэний үүргээ биелүүлж, засрах төлөв байдлаа харуулж байгаагийн илрэл учраас ял хөнгөрүүлэх шалтгаан болно гэж тодорхойлсон байдаг.¹

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад 12 зүйл бүхий “Авлигын гэмт хэрэг” бүлгийг шинээр оруулсан бөгөөд авлигын гэмт хэрэг нь нийтийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэргээр төр, засгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, нийтийн ашиг сонирхолд халдаж хуульд заасан гэм хор учруулсан буюу учруулах байсан Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэл юм.

Хэдийгээр авлигатай тэмцэхэд чухал нөлөө үзүүлэх гол зохицуулалт болох авлига, хахууль өгөх гэмт хэргийн талаар хуульд бүлэг бүхий зохицуулалт орсон ч хуулийн дутуу зохицуулалтын улмаас авлигын гэмт хэрэг буурахгүй байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын “Тайлбар” хэсэгт “хясан боогдуулсны улмаас” гэж нөхцлийг тодорхойлсон байгаа нь авлига өгсөн хүн гэмт үйлдэлдээ гэмшсэн байх гол нөхцлийг орхигдуулж зөвхөн хясан боогдуулсан нөхцөл тогтоогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа нь авлига өгөх гэмт хэрэг илрэхгүй байх шалтгаан болж байна.

¹ Г.Совд, БНМАУ-ын эрүүгийн хуулийн тайлбар, 1982

Дэлхийн олон улс оронд авлига өгөх гэмт хэргийг сайн дураар хэргээ илчилсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар хуульчилсан байна. Дэлхийн улс орнуудаас жишээ болгож авч үзвэл:

Оросын Холбооны Улс - Эрүүгийн хуулийн 291 дүгээр зүйл "Хахууль өгөх" Эрүүгийн хуулийн 291 дүгээр зүйлийн "Тэмдэглэл" (примечание)² "хахууль өгөхийг шаардсан, хясан боогдуулсны улмаас, эсвэл хахууль өгснөө сайн дураараа эрх бүхий байгууллагад мэдэгдэн, гэмт хэргийг илрүүлэхэд идвэхтэй хувь нэмэр, оруулсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө" гэж тусгасан байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс- Тус улсын Эрүүгийн хуулийн 67, 68, 78 дугаар зүйлүүдэд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх болон хөнгөрүүлэх нийтлэг нөхцөлийг тодорхой тусгаж өгсөн. Гэмт этгээд өөрөө сайн дураараа гэмт буруугаа хүлээж, тохирсон эрүүгийн хариуцлагаа хүлээхээр зөвшөөрсөн тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх нийтлэг нөхцөлийг хэрэглэж байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрүүлэх, хэрэг илрүүлэхэд хамтран ажиллуулах, чухал баримт сэлтийг гаргаж өгүүлэх үйлдлийг дэмжих, хууль сахиулах байгууллага болон шүүх байгууллагуудын ажлыг оновчтой хуваарилах, ачаалал бууруулах хүрээнд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхээр 2019 онд тус улсын Ардын дээд шүүх, Ардын дээд прокурор, Нийгмийг аюулаас хамгаалах яам, Улсын аюулаас хамгаалах яам, Хууль зүйн яам хамтран "Гэмт хэргээ өөрөө сайн дураар хүлээн, эрүүгийн хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн иргэнд хэрэглэх удирдамж"-ийг баталсан байна (The Supreme People's Procuratorate, 2019). Энэхүү удирдамжаар эрүүгийн хэргийн хүнд, хөнгөн байдал, ялын шинжээс үл хамааран гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн сэжигтэн, шүүгдэгчийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсхүл ялыг хөнгөрүүлэх боломжтойг тодотгосон байна.

Тус улсын Эрүүгийн хуулийн 390, 392 дугаар зүйлүүдэд хахууль өгөгч этгээд сайн дураар өөрийн үйлдсэн гэмт хэргээ хүлээснээр болзолт шаардлагагүйгээр эрүүгийн хариуцлагаас хөнгөрүүлэх болон чөлөөлөх зохицуулалтыг тусгасан. Хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх тусгай зохицуулалтыг Эрүүгийн тусгасан байдаг.

Хахууль өгсөн этгээд эрүүгийн хариуцлага хүлээхээр шалгагдахаасаа өмнө өөрийн гэмт хэрэг, үйлдлээ сайн дураар хүлээн зөвшөөрвөл шийтгэлийг хөнгөрүүлж эсхүл чөлөөлж болно. Хахууль дамжуулсан этгээд эрүүгийн хариуцлага хүлээхээр шалгагдахаасаа өмнө өөрийн үйлдлийг сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол ялыг хөнгөрүүлж, чөлөөлж болно.

² <https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/ru/ru080en.pdf>

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс- тус улсын Эрүүгийн хууль (Strafgesetzbuch) нь 1871 оны 5 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан бөгөөд тус хуулийн 466, 49, 51 дугаар зүйлүүдэд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх болон хөнгөрүүлэх нийтлэг нөхцөлийг тусгасан. Харин 2009 онд Холбооны Засгийн газраас баталсан “Гэрчийг хамгаалах хөтөлбөр”-өөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэм буруу болон хариуцлагын хэлцэл хийх боломжийг бүрдүүлж өгсөн байдаг. Гэмт этгээд өөрөө сайн дураараа гэм буруугаа хүлээж, тохирсон эрүүгийн хариуцлага хүлээхээр зөвшөөрсөн тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх болон хөнгөрүүлэх боломжтой байдаг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 46b зүйлд зааснаар, хахууль өгөх гэмт хэрэгт холбогдсон этгээд нь өөрийн гэмт үйлдлээ сайн дураар илчилж, эрүүгийн хариуцлагаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд дараах үндэслэлүүдийг харгалзан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх зохицуулалтыг хэрэглэнэ. Үүнд:

- сайн дураар гэмт үйлдлээ илчлэх;
- ил болсон баримтын чухал байдал;
- гэмт хэргийн хүрээ;
- баримтыг илчилсэн цаг хугацаа;
- хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан байдал;
- гэмт хэргийн ангилал зэргээс хамаарч эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх болон хөнгөрүүлнэ.

Швейцарын Холбооны Улс - Эрүүгийн хууль (Strafgesetzbuch, StGB) нь 1937 оны 12 дугаар сарын 21- ны өдөр батлагдсан. Тус улсаас авлигатай тэмцэх стратегид авлига нь төр, нийгэм, эдийн засагт ноцтой хохирол учруулдаг тул түүнтэй цогцоор нь тэмцэх ёстой гэж үзсэн. Хахууль өгөхтэй холбоотой зохицуулалтыг Швейцарын Эрүүгийн хуулийн 331-338 дугаар зүйлүүдээр зохицуулдаг. Үүнд:

Хахууль өгөх - Шүүхийн болон бусад эрх бүхий байгууллагын гишүүн, төрийн албан хаагч, албан ёсоор томилогдсон шинжээч, орчуулагч, хэлмэрч, арбитрч, зэвсэгт хүчний алба хаагчдын хүлээсэн үүргээ урвуулан ашиглаж гуравдагч этгээдэд хууль бус давуу байдал санал болгосон, амласан үйлдэл (§322^{ter}).

Давуу байдал олгох - Шүүхийн болон бусад эрх бүхий байгууллагын гишүүн, төрийн албан хаагч, албан ёсоор томилогдсон шинжээч, орчуулагч, хэлмэрч, арбитрч, зэвсэгт хүчний алба хаагчдын хүлээсэн үүргээ урвуулан ашиглахад нөлөөлөх зорилгоор гуравдагч этгээдэд хууль бус давуу байдал санал болгосон, амласан, олгосон үйлдэл (§322)

Мөн Евро Комисс болон Швейцар Улс хамтран Европын Холбооны авлигатай тэмцэх шинэ дүрмийн удирдамжийн төслийг 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн

байна. Энэхүү удирдамжид хувийн хэвшилд холбогдох авлигыг гэмт хэрэгт тооцох шаардлагыг тодорхойлж, авлигын гэмт хэргийн аюул занал, түүний хувьсан өөрчлөгдөж буй байдалтай уялдуулан гишүүн орнуудын Эрүүгийн хуулийн харилцан адилгүй зохицуулалтыг нэг мөр болгох, уялдаа холбоотой, хамтын ажиллагааг дэмжсэн хуулийн тогтолцоог бүрдүүлэх үүргийг тусгасан. Тус төслийн 18 дугаар зүйлд авлигын болон албан тушаалын гэмт хэргийн холбогдогчийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөлийг анх удаа нарийвчлан тусгасан. Үүнд:

- гэмт хэрэгтэн эрх бүхий байгууллагад сайн дураараа хандаж, мөрдөн шалгах ажиллагаанд чухал нотлох баримт гаргаж өгсөн;
- шүүхийн байгууллагад бусад холбогдогч этгээдийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн;
- нотлох баримт нэмэлтээр гаргаж өгсөн;
- гэмт үйлдлийн үр дагаврыг арилгах, залруулах арга хэмжээг шуурхай авсан зэрэг нь эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэлд хамаарна.

Япон Улс - Япон Улсын 1907 оны 4 сарын 24-ны өдөр баталсан Эрүүгийн хуулиар гэмт этгээд сайн дураараа гэмт буруугаа хүлээсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, зарим тохиолдолд чөлөөлөх зохицуулалтыг тус хуулийн 42, 43 зүйлүүдэд тусгасан байдаг. Авлигтай холбоотой Эрүүгийн хуулийн холбогдох заалтууд:

Хахууль авах - Төрийн албан хаагч (төрийн албанд томилогдох этгээд) албан үүргээ гүйцэтгэхдээ хахууль авсан, гуйсан, авахаар амласан үйлдэл (§197).

Гуравдагч этгээдэд хахууль дамжуулах - Төрийн албан хаагч гуравдагч этгээдэд хахууль өгөхөөр тохиролцсон, эсвэл хахууль өгөхийг амласан үйлдэл (§197.2).

Нөлөөллийн төлөө хахууль авах - Төрийн албан хаагч өөр төрийн албан хаагчид нөлөөлөх зорилгоор хууль бус ашиг авах, гуйх, авахыг зөвшөөрөх (§197.4).

Авлига өгсөн этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сэжигтнээр тооцогдохоос өмнө сайн дураараа мэдүүлэг өгч, хэрэг илрүүлэхэд чухал нотлох баримт гаргаж өгсөн бол прокурорын байгууллага хариуцлагыг хөнгөрүүлж, зарим тохиолдолд чөлөөлж болно.

Бүгд Найрамдах Солонгос Улс- Эрүүгийн хууль 1953 онд батлагдсан бөгөөд гэмт этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөлийг тухайн гэмт хэргийн ангилал, оногдуулах ялын хэмжээнд тулгуурлан тодорхойлдог.

“Авлигын эсрэг хууль” нь төрийн албан хаагчдыг зүй бусаар урих, өндөр үнэтэй эд зүйл авах, хандив тусламж авах, бэлэг сэлт солилцох үйлдлийг хориглосон. Энэ хууль нь төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, олон нийтийн итгэлийг хамгаалах гол зорилготой. Хуулиар төрийн албан хаагч бусдаас авч болох бэлэг, мөнгөний хэмжээ, хандив, урамшуулал, томилолтын зардал зэрэгт нарийн хязгаар тогтоосон байдаг.

БНСУ-ын Эрүүгийн хуулийн авлигын зүйл заалтуудаас хахууль өгөх заалтыг иш татвал:

Хахууль өгөх - Эрүүгийн хуулийн 129-132 дугаар зүйлд заасан хэлбэрийн дагуу хахууль өгөхөөр амлах, өгөх, хүсэл зоригоо илэрхийлэх үйлдэл (§133).

Гэмт хэрэг үйлдсэн этгээд сайн дураар мэдүүлэг өгч, гэмт хэргийг илрүүлэхэд чухал баримт гаргаж өгсөн, мөрдөн байцаалтад идэвхтэй хамтран ажилласан бол, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэхийг шүүгч болон прокурор шийдвэрлэдэг. Мөн сайн дураараа мэдээлж, үүний үр дүнд гэмт хэрэг илэрсэн бол эрүүгийн шийтгэл, захиргааны торгууль, сахилгын шийтгэл зэргийг хөнгөрүүлэх боломжтой гэж хуульчилсан.

Бүгд Найрамдах Казахстан Улс-Эрүүгийн хуулийн 312 дугаар зүйл “Авлига өгөх”
Хэрэв хахууль өгсөн этгээд төрийн чиг үүрэг гүйцэтгэх эрх бүхий этгээд буюу түүнтэй адилтгах этгээдийн өмнөөс хахууль нэхэмжилсэн, эсхүл тухайн этгээд хахууль өгсөн тухайгаа хахууль өгсөнтэй холбоотой эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

Хэрэв төрийн албан үүрэг гүйцэтгэх эрх бүхий этгээд, эсхүл түүнтэй адилтгах этгээд авлига өгөхийг шаардан сүрдүүлсэн бол, эсхүл тухайн хүн авлига өгсөн тухайгаа сайн дураараа эрх бүхий байгууллагад мэдэгдсэн тохиолдолд, авлига өгсөн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэж хуульд нь заасан байдаг.

Бүгд Найрамдах Беларусь Улс- Эрүүгийн хуулийн 431 дүгээр зүйл “Хахууль өгөх”

1. Хахууль өгөх- хоёр жил хүртэл хугацаагаар торгох, эсхүл засварын ажил хүчээр хийлгэх, эсхүл баривчлах, эсхүл эрх чөлөөг хоёр жил хүртэлх хугацаагаар хязгаарлах (торгуультай эсхүл торгуульгүй), эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял (торгуультай эсхүл торгуульгүй) ногдуулах шийтгэлтэй.

2. Давтан, их хэмжээний, эсхүл албан тушаалын байдлаа ашиглан хахууль өгсөн бол эрх чөлөөг таван жил хүртэл хугацаагаар хязгаарлах (торгуультай эсхүл торгуульгүй), эсвэл 2-7 жил хүртэл хугацаагаар хорих ял (торгуультай эсхүл торгуульгүй) ногдуулна.

3. Маш их хэмжээний хахууль өгөх, эсвэл энэ зүйл болон 430, 432 дугаар зүйлүүдээр өмнө нь ял шийтгэл хүлээж байсан этгээд дахин авлига өгсөн бол 5-10 жил хүртэл хугацаагаар хорих ял (торгуультай эсхүл торгуульгүй) онооно.

Тэмдэглэл: Хэрэв хахууль өгсөн этгээд хахуулийг гарцаагүй байдалд өгсөн бол, эсвэл хахууль өгсний дарга энэ тухайгаа сайн дураараа хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад мэдэгдэж, гэмт хэргийг илрүүлэх болон мөрдөн шалгах ажиллагаанд идэвхтэй тусалсан бол уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

Бүгд Найрамдах Энэхтхэг Улс- “Авлигаас урьдчилан сэргийлэх тухай” хууль (РСА)
2018 оны нэмэлт, 8 дугаар зүйл: Нийтийн албан хаагчийг албан үүргээ буруу хэрэгжүүлэх, эсвэл урамшуулах зорилгоор өөр этгээдэд ямар нэгэн шударга бус давуу байдал (undue

advantage) амласан эсхүл өгсөн хүн нь долоон жил хүртэл хугацаагаар хорих ял, эсвэл торгууль, эсвэл энэ хоёр ялыг зэрэг хэрэглэх шийтгэлтэй.

б. Харин уг этгээд нь тухайн шударга бус давуу байдлыг албадлагын шахалт, сүрдүүлгийн улмаас өгсөн бөгөөд өгснөөс хойш долоо хоногийн дотор хууль сахиулах байгууллагад мэдэгдсэн бол энэ заалт түүнд хамаарахгүй.

с. Мөн энэхүү шударга бус давуу байдал (авлига) нь гуравдагч этгээдийн гар дамжсан эсэх, эсвэл нийтийн албан хаагч өөрөө хүлээн авсан эсэх нь хамааралгүй- тухайн хүн авлигын өгөгч бол уг заалт үйлчилнэ.

Мөн арилжааны байгууллагууд (Commercial Organizations, CO) төрийн албан хаагчдад авлига өгдөг гэх хардлагаас болж төрийн байгууллагуудаас дарамт шахалт авах эрдсэлтэй гэж үздэг.

Ийм нөхцөлд хууль хэрэгжүүлэгч байгууллага, прокурор, шүүхийн байгууллагуудын чадавх, хараат бус байдал, мэргэжлийн ур чадвар, шийдвэр гаргах эрх мэдэл онцгой ач холбогдолтой болдог.

Бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад Энэтхэг улс эдгээр байгууллагуудын автономит байдал, чадамж, шийдвэр гаргах чөлөөт байдлыг нэмэгдүүлж, авлигын хэргийг мэргэжлийн түвшинд бодитоор шийдвэрлэх шаардлагатай гэж үздэг.

Украин Улс- Эрүүгийн хуулийн 369 дүгээр зүйл “Нийтийн албан тушаалтанд хууль бус ашиг санал болгох, амлах, эсвэл өгөх”³

1. Нийтийн албан тушаалтанд хууль бус ашиг (bribe, improper benefit) санал болгох, амлах, эсвэл өгөх нь гэмт хэрэгт тооцогдоно.

2. Их хэмжээний буюу давтан үйлдэл гаргасан бол илүү хүнд ял ногдуулна.

3. Маш их хэмжээний эсвэл зохион байгуулалттай хэлбэрийн авлига өгсөн бол таван жилээс арав жил хүртэл хугацаагаар хорих ял онооно.

Тэмдэглэл: Хэрэв авлига өгсөн этгээдэд авлигыг нэхэмжилсэн буюу сүрдүүлсэн, эсвэл тухайн этгээд авлига өгсөн тухайгаа сайн дураар мэдэгдэж, мөрдөн шалгах байгууллагад идэвхтэй тусалсан бол уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

Авлигатай хийх тэмцэлд хамгийн чухал нөлөө үзүүлэх этгээд бол авлига өгсөн этгээд гэм буруугаа хүлээх, гэмт үйлдлээ сайн дураараа илчлэх явдал бөгөөд авлига өгөгч этгээдийг гэмт хэргээ сайн дураар илчлэн гэмших байдлыг хамгаалах суурь нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх явдал юм гэдгийг дэлхийн олон улс орны авлигын эсрэг хууль, эрүүгийн хууль зэргээс нь харж болохоор байна.

Монгол Улс авлигатай тэмцэх талаар хийж хэрэгжүүлсэн ажлуудын нэг нь эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэргийн эсрэг эрүүгийн гэмт хэргийн талаарх зохицуулалтууд мөн боловч хязгаарлагдмал хүрээнд буюу зөвхөн “хясан боогдуулсан” гэх шалтгаант нөхцлийг тодорхойлсон явдал юм. Хэрэв хясан боогдуулсан шалтгаант нөхцөл тодорхойлогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхээр байвал гэмт хэрэг үйлдсэн этгээд

³ <https://law.wikireading.ru/h1wQMSabLO>

хуулийн байгууллагатай хамтран ажиллах, сайн дураар хэргээ илчлэх боломжгүй буюу хэргээ нуун дарагдуулах нөхцөл тулгаж байна гэж дүгнэж болохоор байна.

Иймээс авлигтай тэмцэх үйл ажиллагааг бодит болгох үүднээс эрүүгийн хуульд авлига өгсөн этгээд гэмт хэргээ сайн дураар илчлсэн байвал эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг байх зохицуулалтыг оруулах зайлшгүй шаардлагатай байна.

---oOo---

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "авлига" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно гэж тодорхойлсон.

Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлд анхаарал хандуулж "Авилгатай тэмцэх жил", "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-үүдийг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч тухайн хөтөлбөрт тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх талаар үр дүн бүхий бодит үйлдэл хийгдэхгүй байна. Авлигын талаарх ойлголт, түүнийг үл тэвчих байдал нийгэмд, олон нийтийн дунд нэмэгдэж байгаа хэдий ч итгэлцлийг нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх шинэчлэлийн үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулахын тулд Засгийн газрын зүгээс авлигатай тэмцэх талаар шийдвэртэй алхам хийж, авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажлын арга замаа сайжруулах шаардлага үүсэж байна. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батласан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийн зорилгод хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор тодорхой заасан байна.

Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын Тайлбарт "Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө. -Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд хүлээлгэх ялыг хөнгөрүүлэх үндэслэл болно." гэж хуульчилсан.

Дээр дурдсан зүйл, заалтын "Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгсөн" гэж заасан нь гэмт хэргээ сайн дураараа илчлэхэд хязгаарлалт үүсгэж байна. Авлига өгсөн этгээд гэмт үйлдэлдээ гэмших, хэргээ сайн дураар илчлэх нөхцөлд хясан боогдуулсан гэх нөхцөл тогтоогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхээр байгаа нь Авлигатай тэмцэх хөтөлбөрт заагдсан эрх зүйн орчинг бий болгох зайлшгүй шаардлагыг илэрхийлж байна.

2016 онд Улсын Их Хурлын 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд ...авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах, нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, үл тэвчих хандлагыг олон нийтийн дэмжлэг оролцоотойгоор төлөвшүүлэн бүх шатанд авлигыг таслан зогсоосны үндсэн дээр хүний эрхийг ханган нийтийн эрх ашгийг хамгаалж, хувийн

хэвшлийг дэмжин хөгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж "Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа"-г хэрэгжүүлсэн.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад 12 зүйл бүхий "Авлигын гэмт хэрэг" бүлгийг шинээр оруулсан бөгөөд авлигын гэмт хэрэг нь нийтийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэргээр төр, засгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, нийтийн ашиг сонирхолд халдаж хуульд заасан гэм хор учруулсан буюу учруулах гэмт үйлдэл юм.

Дэлхийн олон улс оронд авлига өгсөн этгээд өөрөө хэргээ сайн дураараа илчилж, хуулийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг байна.

Авлигатай үр дүнтэй, бодитоор тэмцэх гол хүчин зүйл болох эрүүгийн хуульд заасан авлига өгөх гэмт хэргийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна.

Хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлд 4,5 дахь заалт болгож Хахууль өгөх гэмт хэргийг үйлдсэн этгээд хахууль өгснөө нэг сарын дотор эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гол зохицуулалт, мөн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын "Тайлбар" хэсгийг хасах, хуулийн хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг зааж өгсөн.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс авлигатай тэмцэхэд бодитой хувь нэмэр оруулах гол эрх зүйн үндэс болно. Түүнчлэн Улсын Их Хурлаар баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжих чухал ач холбогдолтой. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно:

- авлигын гэмт хэргийн тоо эрс буурана;
- албан тушаалтан, эрх бүхий этгээд авлига авахаас эмээнэ;
- Монгол Улсын авлигын эсрэг, авлигыг бууруулах үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжинэ;
- иргэд төрийн аливаа үйлчилгээг чирэгдэл багатай, хурдан шуурхай хуулийн дагуу авдаг болно;
- ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ;

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

---оОо--

/Төсөл/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 22.5 дахь зүйлд дор дурдсан агуулгатай 4,5 дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

“4. Энэ гэмт хэргийг үйлдсэн этгээд хахууль өгснөө нэг сарын дотор эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

5.Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар хахууль өгсөн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын “Тайлбар” хэсгийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батласан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийн зорилго 6-д “авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэх заалтын 6.1.11 дэх хэсэгт “хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж заасан.

Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлд анхаарал хандуулж “Авилгатай тэмцэх жил”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-үүдийг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч тухайн хөтөлбөрт тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх талаар үр дүн бүхий бодит үйлдэл хийгдэхгүй байна. Авлигын талаарх ойлголт, түүнийг үл тэвчих байдал нийгэмд, олон нийтийн дунд нэмэгдэж байгаа хэдий ч итгэлцлийг нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх шинэчлэлийн үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулахын тулд Засгийн газрын зүгээс авлигатай тэмцэх талаар шийдвэртэй алхам хийж, авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажлын арга замаа сайжруулах шаардлага үүсэж байна. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батласан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийн зорилгод хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор тодорхой заасан байна.

Хэдийгээр авлигатай тэмцэхэд чухал нөлөө үзүүлэх гол зохицуулалт болох авлига, хээл хахууль өгөх гэмт хэргийн талаар зохицуулалт учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтад байгаа “хясан боогдуулсны улмаас” гэж нөхцлийг тодорхойлсон байгаа нь авлига өгсөн хүн гэмт үйлдэлдээ гэмшсэн байх гол нөхцлийг орхигдуулж зөвхөн хясан боогдуулсан нөхцөл тогтоогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа нь авлига өгөх гэмт хэрэг илрэхгүй байх шалтгаан болж байна.

Авлига өгсөн этгээдийн тухайд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө” гэсэн нь авлига илрэх ганц шалтгаан бүхий заалт юм. Харамсалтай нь, иргэн өөрөө хүсээд, санаачлаад, зохион байгуулаад төрийн албан хаагчид хахууль өгч ажил хэргээ бүтээсэн байлаа ч энэ үйлдэлдээ гэмшээд хуулийн байгууллагад хандахын тулд хясан боогдуулсан гэдгээ батлах шаардлагатай буюу хязгаарлагдмал нөхцөл үүсээд байна. Учир нь хясан боогдуулсан нөхцөлгүйгээр авлига өгсөн хүнд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалт үйлчлэхгүй буюу

эрүүгийн хариуцлага хүлээх учир авлигын гэмт хэрэг илрэхгүй байна. Энэ нь авлига цэцэглэх нэг суурь болж байгааг үгүйсгэхгүй.

Дэлхийн олон улс оронд авлига өгсөн этгээд өөрөө хэргээ сайн дураараа илчилж, хуулийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг байна.

Авлигатай үр дүнтэй, бодитоор тэмцэх гол хүчин зүйл болох эрүүгийн хуульд заасан авлига өгөх гэмт хэргийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна гэж үзэн Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр, О.Алтангэрэл нар энэхүү хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн /цаашид "Хуулийн төсөл" гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн⁴ 17 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын⁵ 3 дугаар хавсралтаар баталсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"-д заасны дагуу хуулийн төслийн зүйл, заалтын харилцан уялдаа, практикт хэрэгжих боломж, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, улмаар хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлыг харгалзан 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

1. зорилгод хүрэх байдал;
2. ойлгомжтой байдал;
3. зардал;
4. харилцан уялдаа.

⁴ "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Зардал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн нөлөөллөөс иргэн аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагад гарах нэмэгдэл зардлыг үнэлж тооцох.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Тус хуулийн төслийн үзэл баримтлалд дараах үндсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

-Авлига өгсөн этгээд гэм буруугаа ойлгож гэмт хэргээ сайн дураар илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх;

-Монгол Улсын авлигын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг үр дүнтэй болгох, авлигын гэмт хэргийн тоог эрс бууруулах;

-Ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэх;

Хуулийн төслийн үзэл баримтлал	Хуулийн төслийн зохицуулалт
-Авлига өгсөн этгээд гэм буруугаа ойлгож гэмт хэргээ сайн дураар илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх;	- Энэ гэмт хэргийг үйлдсэн этгээд хахууль өгснөө нэг сарын дотор эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

	-Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар хахууль өгсөн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй." Гэх заалтууд нь бүрэн утгаараа хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
-Монгол Улсын авлигын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг үр дүнтэй болгох, авлигын гэмт хэргийн тоог эрс бууруулах;	- Энэ гэмт хэргийг үйлдсэн этгээд хахууль өгснөө нэг сарын дотор эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. - Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын "Тайлбар" хэсгийг хассугай гэх хуулийн төслийн заалтууд нь гэмт хэрэг үйлдсэн этгээд нэгэнт эрүүгийн хариуцлага хүлээхгүй учир гэмт үйлдэлдээ гэмшээд хэргээ хүлээх нь авлигын гэмт хэргийн тоог бууруулахад нөлөөтэй байхын зэрэгцээ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны томоохон зорилтуудын нэг болох авлигатай тэмцэх үйл ажиллагааг бодит үр дүнтэй болгох тул хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
-Ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэх;	Авлига өгөх гэмт хэргийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөнөөр авлига өгсөн этгээдийн гэр бүлийн гишүүн, түүний үйлдлийг мэдэх найз нөхөд нь гэмт хэргээ сайн дураар илчлэхэд ятган нөлөөлөх замаар авлигын гэмт хэргийн илрүүлэлтэд эерэг нөлөө үзүүлж цаашлаад олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэх учир хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.

3.2. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгасан.

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг тогтоох зорилгоор иргэд, олон нийтээс хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд ойлгомжгүй байгаа зохицуулалт байхгүй талаар саналаа ирүүлсэн.

Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан

29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.
30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан

3.3. “Зардал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Төрд үүсэх зардал: Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй. Эрэгээрээ авлигын гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн хураана.

Иргэнд үүсэх зардал: Иргэдэд нэмэлт зардал үүсгэхгүй. Авлига өгсөн этгээд өөрт байгаа нотлох баримтыг гаргаж өгөөд л болох учир иргэнээс аливаа зардал гарахгүй.

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийг бүхэлд нь авч үзсэн.

Хүснэлт 4. Хуулийн төслийг аргачлалын дагуу үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөл нь энэхүү хуулийн төсөлд авлига өгсөн хүн сайн дураар хэргээ илчилснээр эрүүгийн хариуцлагаас

	чөлөөлөгдөх нөхцөл үүсч байгаа нь хуулийн зорилттой нийцэж байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн нэр томъёоны тодорхойлолт тусгагдаагүй.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Нийцсэн байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Давхардуулсан зохицуулалт байхгүй, учир нь төрийн байгууллагын албан тушаалтны гүйцэтгэх чиг үүрэгт хамааралтай зохицуулалтыг хамруулаагүй байна.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төслийн гол зохицуулалт авлигыг, хүнд суртлыг таслан зогсооход чиглэгдэнэ.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм зохицуулалт тусгагдаагүй.

Дээрх судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хууль тогтоомжтой уялдсан бөгөөд давхардалгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Дүгнэлт: Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд хуулийн төслөөр

тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

- Хуулийн төслийн зорилт нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, үндэслэлийг бүрэн илэрхийлж чадсан байна.

- Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөлд тодорхойлсон зорилго, зорилтыг бүрэн илэрхийлсэн байна.

- Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах шаардлагад нийцсэн бөгөөд төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байна.

- Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхэд хуулийн төсөл зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байх тул хуулийн төслийг хэвээр үлдээх нь зүйтэй байна.

---oOo---

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/

Хууль тогтоомжийн тухай хуулийн⁶ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх үүрэг болон тэдгээрийг дагалдан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

1.Төрийн байгууллагын зардал;

2.Хуулийн этгээдийн зардал;

3.Иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр ангилан үүсэх зардлыг тооцож, улмаар холбогдох ачааллыг багасгах, зардлыг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулдаг.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, дараах эерэг үр дагаврыг бүрдүүлнэ.

- Төрийн үйл ажиллагааны хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай авлига, хахууль өгөх байдлыг багасгана.

- Авлига өгсөн этгээд сайн дураараа гэмт хэргээ илчилбэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөнөөр авлигын гэмт хэргийн тоо эрс буурна.

- Авлига өгсөн хүн гэмт үйлдлээ сайн дураар илчилдэг болбол эрх бүхий албан тушаалтан авлига авахаас айж эмээнэ буюу авлига авахгүй байх нөхцөл бүрдэнэ.

- Ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд тус хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагын болон албан тушаалтны чиг үүрэгт өөрчлөлт гарахгүй, давхцал үүсэхгүй.

Өөрөөр хэлбэл, хуулийн өөрчлөлттэй холбоотой үүрэг хүлээгч байгууллагуудад хүний нөөцийн болон захиргааны зардал нэмэлтээр гарахгүй, одоогийн хүний нөөц, үйл ажиллагааны зардалдаа багтаан хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх боломжтой.

Түүнчлэн энэхүү хуулийн төслөөр хувь хүн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт үүрэг хүлээлгээгүй тул хуулийн хэрэгжилттэй холбоотой тэдгээрээс нэмэлт зардал шаардахгүй.

⁶ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

Төрд үүсэх зардал: Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй. Эрэгээрээ авлигын гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн хураана.

Иргэнд үүсэх зардал: Иргэдэд нэмэлт зардал үүсгэхгүй. Авлига өгсөн этгээд өөрт байгаа нотлох баримтыг гаргаж өгөөд л болох учир иргэнээс аливаа зардал гарахгүй.

Иймд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу судлахад төр, хуулийн этгээд ба иргэнд ямар ч нэмэлт зардал үүсэхгүй тул төсөлтэй холбогдуулан зардлыг тооцох шаардлагагүй болно.

--oOo--

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлууд байгаа хэдий ч бодит үр дүн, ахиц гарахгүй байна гэж дүгнэж байна. Засгийн газар өөрөө ч ийнхүү дүгнэж байгаагаа хүлээн зөвшөөрч Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батласан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийн зорилго 6-д “авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэх заалтын 6.1.11 дэх хэсэгт “хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж заасан.

Хэдийгээр Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалт “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө. -Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд хүлээлгэх ялыг хөнгөрүүлэх үндэслэл болно.” гэж хуульчилсан.

Хуульд заасан “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгсөн” гэж заасан нь гэмт хэргээ сайн дураараа илчлэхэд хязгаарлалт үүсгэж байна. Авлига өгсөн этгээд гэмт үйлдэлдээ гэмших, хэргээ сайн дураар илчлэх нөхцөлд хясан боогдуулсан гэх нөхцөл тогтоогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхээр байгаа нь Авлигатай тэмцэх хөтөлбөрт заагдсан эрх зүйн орчинг бий болгох зайлшгүй шаардлагыг илэрхийлж байна.

Авлигын гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, хахууль өгсөн гэмт хэргээ илчилдэг болбол хахууль авах албан тушаалтангүй болох, авлига бодитоор буурах нөхцлийг бүрдүүлэх зорилго бүхий хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр, О.Алтангэрэл нар санаачлан боловсруулсан байна.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр, О.Алтангэрэл нарын санаачлан боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалт “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө. -Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд

санаатайгаар хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд хүлээлгэх ялыг хөнгөрүүлэх үндэслэл болно.” гэж хуульчилсан. Хуулийн “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгсөн” гэж заасан нь гэмт хэргээ сайн дураараа илчлэхэд хязгаарлалт үүсгэж байна. Авлига өгсөн этгээд гэмт үйлдэлдээ гэмших, хэргээ сайн дураар илчлэх нөхцөлд хясан боогдуулсан гэх нөхцөл тогтоогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхээр байгаа нь Авлигатай тэмцэх хөтөлбөрт заагдсан эрх зүйн орчинг бий болгох зайлшгүй шаардлагыг илэрхийлж байгаа нь бодит байна.

Энэхүү хуулийн төслөөр авлигын гэмт хэрэг бууруулахад нөлөө үзүүлэх бодит зорилго хэрэгжихүйц заалтууд болсон байна.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

Хэдийгээр авлигатай тэмцэхэд чухал нөлөө үзүүлэх гол зохицуулалт болох авлига, хээл хахууль өгөх гэмт хэргийн талаар зохицуулалт учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтад байгаа “хясан боогдуулсны улмаас” гэж нөхцлийг тодорхойлсон байгаа нь авлига өгсөн хүн гэмт үйлдэлдээ гэмшсэн байх гол нөхцлийг орхигдуулж зөвхөн хясан боогдуулсан нөхцөл тогтоогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа нь авлига өгөх гэмт хэрэг илрэхгүй байх шалтгаан болж байна.

Авлига өгсөн этгээдийн тухайд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалтын “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө” гэсэн нь авлига илрэх ганц шалтгаан бүхий заалт юм. Харамсалтай нь, иргэн өөрөө хүсээд, санаачлаад, зохион байгуулаад төрийн албан хаагчид хахууль өгч ажил хэргээ бүтээсэн байлаа ч энэ үйлдэлдээ гэмшээд хуулийн байгууллагад хандахын тулд хясан боогдуулсан гэдгээ батлах шаардлагатай буюу хязгаарлагдмал нөхцөл үүсээд байна. Учир нь хясан боогдуулсан нөхцөлгүйгээр авлига өгсөн хүнд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалт үйлчлэхгүй буюу эрүүгийн хариуцлага хүлээх учир авлигын гэмт хэрэг илрэхгүй байна. Энэ нь авлига цэцэглэх нэг суурь болж байгааг үгүйсгэхгүй.

Дэлхийн олон улс оронд авлига өгсөн этгээд өөрөө хэргээ сайн дураараа илчилж, хуулийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг байна.

Авлигатай үр дүнтэй, бодитоор тэмцэх гол хүчин зүйл болох эрүүгийн хуульд заасан авлига өгөх гэмт хэргийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна.

Хуулийн төслөөр авлигыг илрүүлэхэд чухал нөлөө үзүүлэх субъект болох хахууль өгөгч хэргээ сайн дураар илчлэх үйлдэл бөгөөд ийнхүү гэмт хэргээ сайн дураар илчлэхэд нөлөөлөх хүчин зүйл бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх явдал мөн.

Иймд энэхүү хуулийн төсөл нь цаг үеэ олсон, хуулийн дутуу зохицуулалтыг нөхөж чадахуйц, хуулийн төслийн үзэл баримтлалын зорилгыг хэрэгжүүлж, зохицуулахад чиглэсэн чухал шаардлагатай хуулийн төсөл болсон байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Энэхүү үе шатанд тухайн асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, ямар асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хүрэх үр дүнг тодорхойлно. Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс авлигатай тэмцэхэд бодитой хувь нэмэр оруулах гол эрх зүйн үндэс болно. Түүнчлэн Улсын Их Хурлаар баталсан Авлигтай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжих чухал ач холбогдолтой.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно:

- авлигын гэмт хэргийн тоо эрс буурана;
- албан тушаалтан, эрх бүхий этгээд авлига авахаас эмээнэ;
- Монгол Улсын авлигын эсрэг, авлигыг бууруулах үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжинэ;
- иргэд төрийн аливаа үйлчилгээг чирэгдэл багатай, хурдан шуурхай хуулийн дагуу авдаг болно;
- ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ;

Иймд судалгааны дүнд гарсан асуудлыг шийдвэрлэх үүднээс зорилгыг “Хахууль өгөгч гэмт хэргийг үйлдсэн этгээд хахууль өгснөө нэг сарын дотор эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө” гэж тодорхойллоо.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Илүү зардал гарахгүй
2	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Одоогийн тулгамдаж буй асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.

Дээрхээс дүгнэвэл асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зорилтод хүрэхийн тулд боловсруулсан хуулийн төсөл нь үр дүнтэй хувилбар байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Төрөөс гаргаж буй аливаа шийдвэр нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хамгаалахад чиглэдэг учир асуудлыг зохицуулахаар сонгож буй хувилбар нь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчсөн, хууль бусаар хязгаарласан байх ёсгүй ба тухайн хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө аливаа хэлбэрээр зөрчигдөх ёсгүй. Иймд үүнийг урьдчилан шалгасан байх шаардлагатай тул энэ хэсэгт шалгах болно.

Доорх хүснэгтэд зохицуулалтын хувилбаруудын хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд хариултын тайлбарыг дэлгэрэнгүй байдлаар тусад нь бичсэн болно.

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2. Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл	Тийм	Шударга ёсны зарчимд нийцнэ

	хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх			
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	энэ асуудалтай холбогдолгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Энэ хэсэгт хүний бүхий л эрх, эрх чөлөөг тэгш хориглосон, хязгаарласан зохицуулалтын хувилбарууд байхгүй.

5.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Дотоодын зах зээлийн	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Зардал гарахгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

5.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм		Сайн дураар хэргээ илчилбэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Авлигын гэмт хэрэг буурна
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Авлигын гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдэх буюу Эерэгээр нөлөөлнө
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

Зохицуулалтын хувилбар нь гэмт хэргийн илрүүлэлт, авлигын гэмт хэргийн бууралтад чухал нөлөө үзүүлэхээр байна.

5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААГ

Д/Д	Улс орнууд	Авлига өгөх гэмт хэргийн зохицуулалт
1	Монгол Улс	Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь заалт “Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө. -Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд хүлээлгэх ялыг хөнгөрүүлэх үндэслэл болно.”
2	Оросын Холбооны Улс	Эрүүгийн хуулийн 291 дүгээр зүйл “Хахууль өгөх” Эрүүгийн хуулийн 291 дүгээр зүйлийн “Тэмдэглэл” (примечание) ⁷ “хахууль өгөхийг шаардсан, хясан боогдуулсны улмаас, эсвэл хахууль өгснөө сайн дураараа эрх бүхий байгууллагад мэдэгдэн, гэмт хэргийг илрүүлэхэд идвэхтэй хувь нэмэр, оруулсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө” гэж тусгасан байна
3	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Эрүүгийн хуулийн 390, 392 дугаар зүйлүүдэд хахууль өгөгч этгээд сайн дураар өөрийн үйлдсэн гэмт хэргээ хүлээснээр болзолт шаардлагагүйгээр эрүүгийн хариуцлагаас хөнгөрүүлэх болон чөлөөлөх зохицуулалтыг тусгасан. Хахууль өгсөн этгээд эрүүгийн хариуцлага хүлээхээр шалгагдахаасаа өмнө өөрийн гэмт хэрэг, үйлдлээ сайн дураар хүлээн зөвшөөрвөл шийтгэлийг хөнгөрүүлж эсхүл чөлөөлж болно.
4	Холбооны Бүгд	ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 46b зүйлд зааснаар, хахууль өгөх гэмт хэрэгт холбогдсон этгээд нь өөрийн гэмт үйлдлээ сайн дураар

⁷ <https://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/ru/ru080en.pdf>

	Найрамдах Герман Улс	илчилж, эрүүгийн хариуцлагаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд дараах үндэслэлүүдийг харгалзан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх зохицуулалтыг хэрэглэнэ.
5	Япон Улс	Авлига өгсөн этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сэжигтнээр тооцогдохоос өмнө сайн дураараа мэдүүлэг өгч, хэрэг илрүүлэхэд чухал нотлох баримт гаргаж өгсөн бол прокурорын
6	Бүгд Найрамдах Солонгос Улс	Гэмт хэрэг үйлдсэн этгээд сайн дураар мэдүүлэг өгч, гэмт хэргийг илрүүлэхэд чухал баримт гаргаж өгсөн, мөрдөн байцаалтад идэвхтэй хамтран ажилласан бол, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэхийг шүүгч болон прокурор шийдвэрлэдэг. Мөн сайн дураараа мэдээлж, үүний үр дүнд гэмт хэрэг илэрсэн бол эрүүгийн шийтгэл, захиргааны торгууль,
7	Бүгд Найрамдах Казахстан Улс	Эрүүгийн хуулийн 312 дугаар зүйл "Авлига өгөх" Хэрэв хахууль өгсөн этгээд төрийн чиг үүрэг гүйцэтгэх эрх бүхий этгээд буюу түүнтэй адилтгах этгээдийн өмнөөс хахууль нэхэмжилсэн, эсхүл тухайн этгээд хахууль өгсөн тухайгаа хахууль өгсөнтэй холбоотой эрх бүхий

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Авлигатай хийх тэмцэлд хамгийн чухал нөлөө үзүүлэх этгээд бол авлига өгсөн этгээд гэм буруугаа хүлээх, гэмт үйлдлээ сайн дураараа илчлэх явдал бөгөөд авлига өгөгч этгээдийг гэмт хэргээ сайн дураар илчлэн гэмших байдлыг хамгаалах суурь нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх явдал юм гэдгийг дэлхийн олон улс орны авлигын эсрэг хууль, эрүүгийн хууль зэргээс нь харж болохоор байна.

Монгол Улс авлигатай тэмцэх талаар хийж хэрэгжүүлсэн ажлуудын нэг нь эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэргийн эсрэг эрүүгийн гэмт хэргийн талаарх зохицуулалтууд мөн боловч хязгаарлагдмал хүрээнд буюу зөвхөн "хясан боогдуулсан" гэх шалтгаант нөхцлийг тодорхойлсон явдал юм. Хэрэв хясан боогдуулсан шалтгаант нөхцөл тодорхойлогдохгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхээр байвал гэмт хэрэг үйлдсэн этгээд хуулийн байгууллагатай хамтран ажиллах, сайн дураар хэргээ илчлэх боломжгүй буюу хэргээ нуун дарагдуулах нөхцөл тулгаж байна гэж дүгнэж болохоор байна.

Иймээс авлигатай тэмцэх үйл ажиллагааг бодит болгох үүднээс эрүүгийн хуульд авлига өгсөн этгээд гэмт хэргээ сайн дураар илчлсэн байвал эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг байх зохицуулалтыг оруулах зайлшгүй шаардлагатай хуулийн төсөл байна.